



2018 оны 11 дүгээр сарын 19
№43/1048/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр,
тэтгэмжийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын
хууль**

**Нийгмийн даатгалын сангаас
олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай
хуульд нэмэлт оруулах тухай**

**Монгол Улсын
олон улсын
гэрээ**

**Иргэний агаарын хөлгийн
худалдааны хэлэлцээр**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

378.	Хэлэлцээрт нэгдэн орох тухай	1429
379.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1429
380.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	1430
381.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1430
382.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	1431

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

383.	Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр	1432
------	--	------

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 10 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭРТ НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1979 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Швейцарын Холбооны Улсын Женев хотод байгуулсан Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 10 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “7 жилийн цалин хөлсний



нийлбэрийг 84-т” гэснийг “5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д” гэж, “7 хүртэл жил” гэснийг “5 хүртэл жил” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 10 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдөр баталсан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалт:

“3/нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй хугацаагаар хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж, тэтгэврийн



даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь мөн нөхцөлд ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол тус тус өөрийн хүсэлтээр.”

2/25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, 8, 9 дэх заалт:

“7/Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулсан тухай нийгмийн даатгалын байгууллагаас олгосон баримт, лавлагаа;

8/иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл лавлагаа;

9/энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан болзлоор тэтгэвэр тогтоолгох бол энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 7, 8-д заасан баримт бичгийг болон хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтэр, тухайн үед оршин сууж байсан тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, малчнаар ажилд томилсон, чөлөөлсөн тухай тушаал, эсхүл хөлсөөр ажиллах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, эсхүл тэдгээртэй адилтгах гэрээ, 1995 оноос хойш малчнаар ажилласныг нотлох “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого”-ын бүртгэл, лавлагаа.”

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хөдөлмөрийн” гэсний дараа “хортой,” гэж, “халуун” гэсний дараа “, хүнд” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтын “хөдөлмөрийн” гэсний дараа “хортой,” гэж тус тус нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР,
ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлаас 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр,



тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн үйлчлэлд хамрагдах иргэний тэтгэврийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн тогтоож хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ИРГЭНИЙ АГААРЫН ХӨЛГИЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

Удиртгал

Иргэний агаарын хөлгийн худалдааны Хэлэлцээрт (цаашид “энэ Хэлэлцээр” гэх) Нэгдэн оролцогч талууд¹;

Сайд нар 1973 оны 9 дүгээр сарын 12-ноос 14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Олон талт худалдааны хэлэлцээний Токиогийн үе шатаар дэлхийн худалдааны тэлэлт болон илүү либералчлалд худалдаанд учирдаг саад бэрхшээлийг аажмаар үгүй болгох, дэлхийн худалдааны үйл ажиллагаа явуулдаг олон улсын тогтолцоог сайжруулах замаар хүрэх ёстойг хүлээн зөвшөөрснийг Тэмдэглэж;

Иргэний агаарын хөлөг, эд анги, холбогдох тоног төхөөрөмжийн дэлхийн худалдааг хамгийн дээд эрх чөлөөнд хүргэж, түүний дотор гаалийн хурамжаас чөлөөлөх болон боломжит дээд хэмжээнд худалдааны хязгаарлалт, гажуу нөлөөллийг бууруулах, үгүй болгохыг Эрмэлзэж;

Нисэхийн салбарын технологийн цаашдын хөгжлийг дэлхийн хэмжээнд хөхиүлэн дэмжихийг Эрмэлзэж;

Иргэний агаарын хөлгийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэгчдийг Дэлхийн иргэний агаарын хөлгийн зах зээлийг өргөжүүлэхэд оролцоход нь өрсөлдөөний шударга, тэгш боломжоор хангахыг Эрмэлзэж;

Иргэний агаарын хөлгийн салбарын эдийн засгийн болон худалдааны нийтлэг ашиг сонирхлын чухлыг Харгалзаж;

¹“Нэгдэн оролцогч талууд” гэх ойлголт нь цаашид энэ Хэлэлцээрийн Талууд гэх утгаар ашиглагдана.

Агаарын хөлгийн салбар нь эдийн засгийн болоод үйлдвэрлэлийн бодлогын онцгой чухал бүрэлдэхүүн гэж Нэгдэн оролцогч ихэнх талууд үзэж буйг Зөвшөөрч;

Засгийн газрын дэмжлэг өөрөө худалдааны гажуудал мэт үзэгдэхгүй гэдгийг зөвшөөрөхийн зэрэгцээ, Иргэний агаарын хөлгийн хөгжил, үйлдвэрлэл, маркетингт үзүүлэх Засгийн газрын дэмжлэгийн улмаас үүсэх иргэний агаарын хөлгийн худалдаанд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахыг Эрэлхийлж;

Иргэний агаарын хөлгийн үйл ажиллагааг арилжааны өрсөлдөөний үндсэн дээр явуулахыг Эрмэлзэж, үүний доторх засгийн газар-үйлдвэрлэгч хоорондын харилцаа нь ихээхэн ялгаатай гэдгийг хүлээн зөвшөөрч;

Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр /цаашид “ТХЕХ” гэх/ болон ТХЕХ - ийн ивээл дор хэлэлцэгдсэн олон талт хэлэлцээрийн дагуу олгогдсон талуудын эрх, үүргийг хүлээн Зөвшөөрч;

Энэ Хэлэлцээрийн заалтуудын шударга, шуурхай, үр дүнтэй хэрэгжилтийг хангах зорилготойгоор олон улсын мэдэгдэл, зөвлөгөөн, тандалт болон маргаан шийдвэрлэх процедураар хангах болон үүн доторх эрх, үүргийн тэнцвэрийг хадгалах хэрэгцээ шаардлагыг Зөвшөөрч;

Иргэний агаарын хөлгийн худалдаан дах засаглалын олон улсын тогтолцоог бий болгохыг Эрмэлзэж;

Дараах зүйлсийг харилцан тохиролцов:

1 дүгээр зүйл **Бүтээгдэхүүний хамрах хүрээ**

1.1 Энэхүү хэлэлцээр нь:

- a) иргэний агаарын бүх хөлөг;
- b) иргэний агаарын бүх хөлгийн хөдөлгүүр, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсэг;
- c) иргэний агаарын хөлгийн бусад бүх эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг;
- d) газар дээрх нислэгийн бүх дадлагажуур болон түүний эд анги, бүрэлдэхүүн хэсэг.

Иргэний агаарын хөлгийн үйлдвэрлэл, засвар, үйлчилгээ, сэргээн босголт, өөрчлөлт, эсхүл хувиргалтад үндсэн, эсхүл орлуулагч төхөөрөмжөөр алинаар нь ашиглагдаж буйгаас үл хамаарна.



- 1.2 Энэ Хэлэлцээрийн зорилгын хүрээнд “Иргэний агаарын хөлөг” гэж (а) цэргийн зориулалтын агаарын хөлгөөс бусад бүх агаарын хөлөг, (б) дээрх 1.1-т заасан бүх бүтээгдэхүүнийг хэлнэ.

2 дугаар зүйл

Гаалийн татвар ба бусад хураамж

- 2.1 Нэгдэн оролцогч талууд дараах зүйлийг зөвшөөрөв. Үүнд:
- 2.1.1 1980 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, эсхүл энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчлэх өдрөөс эхлэн гаалийн зориулалтаар Хавсралт дахь жагсаалтад харгалзах тарифын гарчгийн дагуу ангилсан бүтээгдэхүүн, хэрэв эдгээр нь үйлдвэрлэл, засвар, үйлчилгээ, сэргээн босголт, өөрчлөлт, эсхүл хувиргалтын явцад агаарын хөлөг, эсхүл түүний угсралтад ашиглах бүтээгдэхүүн бол, түүний импортод ногдуулах, эсхүл түүнтэй холбогдох бүхий л гаалийн татвар болон аливаа бүх төрлийн бусад хураамжийг² арилгахыг;
- 2.1.2 1980 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, эсхүл энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчлэх өдрөөс эхлэн иргэний агаарын хөлгийн засварт ногдуулах бүхий л гаалийн татвар болон бусад хураамжийг арилгахыг;
- 2.1.3 1980 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, эсхүл энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчлэх өдрөөс эхлэн дээрх 2.1.1 дэх хэсэгт заасан бүх бүтээгдэхүүнийг, мөн 2.1.2 дэх хэсэгт заасан бүхий л засварыг татваргүй, эсхүл татвараас чөлөөлөх горимоор өөрсдийн ТХЕХ-ийн харгалзах хуваарьт тусгахыг.
- 2.2 Бүх Нэгдэн оролцогч талууд: (а) дээрх 2.1 дүгээр зүйлд заасан үүргээ хэрэгжүүлэхийн тулд гаалийн захиргааны эцсийн хэрэглээний системд тохируулах, эсхүл системийг авч ашиглана, (b) эцсийн хэрэглээний систем нь бусад Нэгдэн оролцогч талуудын үзүүлж буй татваргүй, эсхүл татвараас чөлөөлөх горимтой ижил байх бөгөөд худалдааны саад болохооргүй байдлыг хангана, (c) бусад Нэгдэн оролцогч талуудад эцсийн хэрэглээний системийн удирдлагын процедурын талаар мэдээлнэ.

²“Бусад хураамж” гэдэг нь ТХЕХ-ийн хоёрдугаар зүйл дэх утгатай адил байна.

3 дугаар зүйл **Худалдаан дахь техникийн саад тотгор**

- 3.1 Нэгдэн оролцогч талууд Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн заалтуудыг иргэний агаарын хөлгийн худалдаанд ашиглахыг тэмдэглэв. Мөн иргэний агаарын хөлгийн үйл ажиллагааны болон засвар үйлчилгээний процедурын гэрчилгээний шаардлага болон үзүүлэлтүүдийг Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн заалтын дагуу талуудын хооронд зохицуулахыг Нэгдэн оролцогч талууд зөвшөөрөв.

4 дүгээр зүйл **Засгийн газрын шууд худалдан авалт, албан журмын туслах хэлэлцээр ба урамшуулал**

- 4.1 Иргэний агаарын хөлгийн худалдан авагч нь арилжааны болон технологийн хүчин зүйлс дээр үндэслэн ханган нийлүүлэгчийг чөлөөтэй сонгоно.
- 4.2 Нэгдэн оролцогч талууд, аливаа Нэгдэн оролцогч талын ханган нийлүүлэгчид чиглэсэн ялгаварлан гадуурхалтыг үүсгэж болзошгүй байдлаар, агаарын тээвэрлэгч, агаарын хөлөг үйлдвэрлэгч, эсхүл иргэний агаарын хөлөг худалдан авахтай холбогдож буй этгээдүүдэд иргэний агаарын хөлгийг аливаа тодорхой эх үүсвэрээс худалдан авахыг шаардах, эсхүл үндэслэлгүй дарамт учруулж болохгүй.
- 4.3 Нэгдэн оролцогч талууд, энэ Хэлэлцээрт хамаарах бүтээгдэхүүний худалдан авалтыг зөвхөн өрсөлдөхүйц үнэ, чанар, нийлүүлэлтийн үндсэн дээр хийхийг зөвшөөрөв.

Хэдий ийм боловч, энэ Хэлэлцээрт хамаарах бүтээгдэхүүний Худалдан авалтын хэлэлцээр байгуулах зөвшөөрөл, эсхүл хэлэлцээр байгуулах эрхтэй холбогдуулан, Нэгдэн оролцогч тал нь өрсөлдөөний үндсэн дээр, бусад Нэгдэн оролцогч талуудын шаардлага хангасан фирмээс дутуугүй, тааламжтай байх нөхцөлтэйгөөр, өөрийн шаардлага хангасан фирмийг бизнесийн боломжоор хангахыг шаардаж болно.³

³ “... дутуугүй тааламжтай байх нөхцөлтэйгөөр, ... бизнесийн боломжоор хангахыг ...” гэсэн хэллэг нь аль нэг Нэгдэн оролцогч талын шаардлага хангасан фирмийн авсан хэлэлцээрийн хэмжээ бусад Нэгдэн оролцогч талуудын шаардлага хангасан фирмийн авсан хэлэлцээрийн хэмжээтэй ижил байна гэсэн утгыг агуулаагүй болно.



- 4.4 Аливаа нэг тодорхой эх үүсвэрээс иргэний агаарын хөлгийг худалдах, худалдан авахад, аль нэг Нэгдэн оролцогч талаас ханган нийлүүлэгчдийн эсрэг ялгаварлан гадуурхах байдал үүсгэх аливаа төрлийн урамшуулал олгохоос зайлсхийхийг Нэгдэн оролцогч талууд зөвшөөрөв.

5 дугаар зүйл
Худалдааны хязгаарлалт

- 5.1 Нэгдэн оролцогч талууд нь иргэний агаарын хөлгийн импортыг хязгаарлах зорилгоор, ТХЕХ-ийн холбогдох заалтуудтай үл нийцэх байдлаар тоон хязгаарлалт /импортын квот/ эсхүл импортын лицензийн шаардлагыг ашиглаж болохгүй. Энэ нь ТХЕХ-тэй нийцсэн импортын хяналт эсхүл лиценз олголтын системд хамаарахгүй.
- 5.2 Нэгдэн оролцогч талууд нь ТХЕХ-ийн холбогдох заалтуудтай үл нийцэх байдлаар, арилжааны эсхүл өрсөлдөөний шалтгаанаар, бусад Нэгдэн оролцогч талууд руу гаргах иргэний агаарын хөлгийн экспортод тоон хязгаарлалт, эсхүл экспортын лицензийн, эсхүл бусад төстэй шаардлагуудыг ашиглаж болохгүй.

6 дугаар зүйл
Засгийн газрын дэмжлэг, экспортын зээл,
агаарын хөлгийн маркетинг

- 6.1 Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн VI, XVI, XXIII зүйлүүдийн Тайлбар ба хэрэглээний тухай хэлэлцээрийн (Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр) заалтыг иргэний агаарын хөлгийн худалдаанд ашиглаж болохыг Нэгдэн оролцогч талууд тэмдэглэв. Иргэний агаарын хөлгийн, тэдний оролцож буй, эсхүл дэмжлэг үзүүлж буй хөтөлбөрүүдэд, талууд Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн 8.3 ба 8.4 дүгээр заалтын үүднээс иргэний агаарын хөлөг худалдах сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийхийг эрэлхийлэхийг батлав. Тэд мөн агаарын хөлгийн салбарт хамаарах тусгай хүчин зүйлүүдийг, ялангуяа энэ талбар дахь засгийн газрын өргөн хүрээний дэмжлэг, тэдний олон улсын эдийн засгийн ашиг сонирхол болон дэлхийн иргэний агаарын хөлгийн зах зээлийн өргөжин тэлэлтэд оролцох гэсэн Нэгдэн оролцогч талуудын үйлдвэрлэгчдийн хүсэл сонирхлыг харгалзан үзэх ёстой.

- 6.2 Нэгдэн оролцогч талууд, иргэний агаарын хөлгийн үнэ нь бүхий л зардлын эргэн төлөлтийн үндэслэл бүхий таамаглалд үндэслэсэн байхыг хүлээн зөвшөөрөв, үүнд, байнгын бус хөтөлбөрийн зардал, тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэлд хожим ашиглагдах агаарын хөлөг, бүрэлдэхүүн хэсэг болон системийн хөгжүүлэлт болон цэргийн судалгааны тодорхой бөгөөд хувь тэнцүүлэх зардал, үйлдвэрлэлийн дундаж зардал болон санхүүгийн зардлууд багтана.

7 дугаар зүйл

Бүсийн болон орон нутгийн засаг захиргаа

- 7.1 Талуудад тус Хэлэлцээрээр олгогдсон үүргээс гадна, Нэгдэн оролцогч талууд нь шууд болон шууд бус байдлаар, бүсийн болон орон нутгийн засаг захиргаа, эрх бүхий байгууллагуудад, төрийн бус болон бусад байгууллагууд нь энэ Хэлэлцээрийн заалтуудтай үл нийцэх арга хэмжээ авахыг шаардах, эсхүл хөхиүлэн дэмжихгүй байхаар зөвшөөрөв.

8 дугаар зүйл

Тандалт, шалгалт, зөвлөгөөн ба маргаан шийдвэрлэлт

- 8.1 Бүх Нэгдэн оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн Иргэний агаарын хөлөг худалдах Хороог (цаашид “Хороо” гэх) байгуулна. Хороо нь өөрийн Даргыг сонгоно. Шаардлагатай үед, гэхдээ энэ Хэлэлцээрийн үйл ажиллагаатай холбогдох аливаа асуудал болон иргэний агаарын хөлгийн салбарын хөгжил, чөлөөт, зөв тогтолцоотой худалдааг үргэлжлүүлэхэд нэмэлт өөрчлөлтүүд шаардагдаж буй эсэхийг тогтоох, хоёр талын зөвлөлдөөнөөр хангалттай шийдэлд хүрэх боломжгүй аливаа асуудлыг нягтлах болон энэ Хэлэлцээрийн дагуу хүлээсэн, эсхүл Нэгдэн оролцогч талуудаас хүлээлгэсэн хариуцлагыг хэрэгжүүлэх зэрэг аливаа асуудлыг зөвлөлдөх боломжийг Нэгдэн оролцогч талуудад олгох зорилгоор жилд нэгээс доошгүй удаа хуралдана.
- 8.2 Хороо нь энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилт болон үйл ажиллагааг түүний зорилгыг харгалзан жил бүр хэлэлцэн шалгана. Хороо нь жил бүр, ТХЕХ-ийн ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОГЧ ТАЛУУД-д тухайн шалгалтын хамрах хугацаан дахь хөгжил дэвшлийн талаар мэдээлнэ.



- 8.3 Тус Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилээс хэтрэхгүй хугацаанд, мөн түүнээс хойш тогтмол хугацаанд, Хэлэлцээрт Нэгдэн оролцогч талууд харилцан ашигтай байх үндсэн дээр энэхүү Хэлэлцээрийг өргөжүүлэх, сайжруулах зорилгоор цаашдын хэлэлцээг явуулна.
- 8.4 Хороо нь, талуудын давуу талын тэнцвэрийг хадгалах зорилгоор энэ Хэлэлцээрийн хэрэгжилтийг тогтмол нягтлахад зохимжтой тийм туслах байгууллагыг байгуулж болно. Тухайлбал, бүтээгдэхүүний хамрах хүрээ, эцсийн хэрэглээний систем, гаалийн татвар болоод бусад хураамжтай холбоотой дээрх 2 дугаар заалтын хэрэгжилттэй холбоотой талуудын давуу талын тэнцвэртэй байдал, харилцан ашигтай болоод адил тэнцүү үр дүнг хангах зорилгоор зохих туслах байгууллагыг байгуулах ёстой.
- 8.5 Нэгдэн оролцогч талууд нь энэхүү Хэлэлцээрийн үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа асуудлаарх өөр Нэгдэн оролцогч талын хийсэн мэдэгдлийн асуудлаар шуурхай зөвлөлдөөн хийх асуудлыг нааштайгаар авч үзэн хангалттай бололцоог олгох ёстой.
- 8.6 Нэгдэн оролцогч талууд нь сэжиг бүхий аливаа татаас байгаа эсэх, түүний хэмжээ болон үр нөлөөг тогтоох шалгалтыг эхлүүлэхээс өмнө талуудын хүлээн авахуйц шийдлийг эрэлхийлэхийн тулд Хорооны Нэгдэн оролцогч бусад талуудтай зөвлөлдөх эрмэлзлийг харгалзан үзнэ. Тийм дотоодын процедурыг эхлүүлэхээс өмнө зөвлөлдөөн хийгээгүй онцгой нөхцөлд, Нэгдэн оролцогч талууд нь тийм процедурыг эхлүүлсэн тухайгаа Хороонд нэн даруй мэдэгдэж, талуудын хүлээн зөвшөөрсөн, хариу арга хэмжээний талаар авах шаардлага үүсэхээс зайлсхийх шийдлийг эрэлхийлэхээр зөвлөлдөөнийг нэгэн зэрэг эхлүүлэх ёстой.
- 8.7 Нэгдэн оролцогч тал нь, иргэний агаарын хөлгийн үйлдвэрлэл, засвар, үйлчилгээ, сэргээн засварлалт, өөрчлөлт эсхүл хувиргалт дахь өөрийн худалдааны ашиг сонирхолд, өөр Нэгдэн оролцогч талын аливаа үйл ажиллагаа сэргөөр нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж байж болзошгүй гэж үзвэл, Хороонд тухайн асуудлыг хянан шалгах тухай хүсэлт гаргаж болно. Тухайн хүсэлтийн дагуу, Зөвлөл нь 30 хоногийн дотор хуралдаан зарлан, ялангуяа өөр бусад газар эдгээр асуудлуудын эцсийн шийдвэрийг гаргахаас өмнө, холбогдох асуудлуудыг аль болох шуурхай шийдвэрлэх зорилгоор аль болох богино хугацаанд

хянан шалгах ёстой. Үүнтэй холбогдуулан, Хороо нь зохих шийдвэр эсхүл зөвлөмжийг гаргаж болно. Тухайн хянан шалгалт нь, иргэний агаарын хөлгийн худалдаанд нөлөөлөх байдлаараа ТХЕХ-ээр эсхүл ТХЕХ-ийн ивээл дор талууд харилцан хэлэлцсэн актын дагуу Нэгдэн оролцогч талуудад олгогдсон эрхэнд хохирол учруулахгүй байна. Холбогдох асуудлуудыг авч үзэхэд тусламж үзүүлэх зорилгын үүднээс, ТХЕХ болон тийм эрх зүйн баримт бичгийн дагуу, Хороо нь зохих байдлаар техникийн туслалцаа үзүүлж болно.

- 8.8 Нэгдэн оролцогч талууд, энэхүү Хэлэлцээрийн хамрах хүрээнд багтах боловч, ТХЕХ-ийн ивээл дор талууд харилцан зөвшилцсөн бусад эрх зүйн баримт бичигт тусгагдаагүй асуудалд холбогдох аливаа маргааны хувьд Ерөнхий хэлэлцээрийн XXII болон XIII зүйлийн заалтууд болон Мэдэгдэл, зөвлөлдөөн, маргаан шийдвэрлэлт болон тандалттай холбоотой Ойлголцлын баримт бичгийн заалтуудыг дүйцүүлэх байдлаар тухайн маргааныг Нэгдэн оролцогч талууд болон Хороо шийдвэрлэх зорилгоор ашиглаж болохыг хэлэлцэн зөвшөөрөв. Маргагч талууд зөвшөөрсөн тохиолдолд, тус Хэлэлцээрт тусгагдсан болон ТХЕХ-ийн ивээл дор талууд харилцан хэлэлцсэн бусад эрх зүйн баримт бичигт тусгагдсан холбогдох аливаа асуудлаар үүсэх маргааныг шийдвэрлэхдээ эдгээр процедурыг мөн хэрэглэнэ.

9 дүгээр зүйл **Төгсгөлийн заалт**

- 9.1 *Хүлээн зөвшөөрөх ба нэгдэн орох*
- 9.1.1 Энэхүү хэлэлцээр нь ТХЕХ-т нэгдэгч Талуудын Засгийн газрууд, Европын Эдийн засгийн нийгэмлэг гарын үсэг зурах эсхүл өөр байдлаар хүлээн зөвшөөрөхөд нээлттэй байна.
- 9.1.2 Энэхүү Хэлэлцээр нь ТХЕХ-т түр нэгдэн орсон засгийн газрууд гарын үсэг зурснаар эсхүл өөр байдлаар хүлээн зөвшөөрөхөд нээлттэй бөгөөд тэдний түр нэгдэн ороход олгогдсон эрх зүйн баримт бичиг дахь эрх, үүргийг харгалзан тус Хэлэлцээрийн дагуу олгогдох эрх, үүргийг үр дүнтэй ашиглах нөхцөлтэй байна.
- 9.1.3 Аливаа бусад засгийн газар энэхүү Хэлэлцээрээр олгогдох эрх, хүлээх үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх



нөхцөлтэйгээр нэгдэн ороход энэ Хэлэлцээр нээлттэй байх бөгөөд нөхцөлийг тухайн засгийн газар Нэгдэн оролцогч талуудтай тохиролцож, ТХЕХ-т нэгдэгч ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОГЧ ТАЛУУДЫН Ерөнхий Захиралд хадгалуулсан хувь нь дурдсан нөхцөлүүдийг тохиролцсон гэдгийн нотолгоо болж нэгдэх эрх зүйн баримт бичиг болно.

9.1.4 Хүлээн зөвшөөрөх тухайд, Ерөнхий хэлэлцээрийн ХХVI:5 зүйл: (а) болон (б)-ын заалтуудыг ашиглаж болно.

9.2 *Тайлбар*

9.2.1 Бусад Нэгдэн оролцогч талуудын зөвшөөрөлгүйгээр тус Хэлэлцээрийн аливаа заалтад тайлбар хийж болохгүй.

9.3 *Хүчин төгөлдөр болох*

9.3.1 Энэхүү Хэлэлцээр нь 1980 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болох ба энэ өдрөөс өмнө хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэгдэн орсон засгийн газруудад⁴ үйлчилнэ.

Бусад засгийн газрын хувьд, энэхүү Хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэгдэн орсон өдрөөс хойш 30 дахь өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

9.4 *Үндэсний хууль тогтоомж*

9.4.1 Энэхүү Хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэгдэн орсон засгийн газар бүр нь, энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө, өөрийн хууль, тогтоомж, захиргааны процедуруудыг энэхүү Хэлэлцээртэй нийцүүлнэ.

9.4.2 Нэгдэн оролцогч талууд нь энэхүү Хэлэлцээртэй холбоотой өөрийн хууль, тогтоомж болон тэдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд орсон аливаа өөрчлөлтийн тухай Хороонд мэдэгдэнэ.

⁴Энэ Хэлэлцээрийн зорилтын хүрээнд, “засгийн газар” гэдэгт Европын Эдийн засгийн Нийгэмлэгийн эрх бүхий байгууллагыг багтаасан гэж үзнэ.

9.5 *Нэмэлт өөрчлөлт*

9.5.1 Нэгдэн оролцогч талууд нь энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад олсон туршлагыг харгалзан үзэж түүнд, түүнчлэн, нэмэлт өөрчлөлт оруулж болно. Тийм нэмэлт өөрчлөлт нь Хорооноос гаргасан процедурын дагуу Нэгдэн оролцогч талууд санал нэгдэж, Нэгдэн оролцогч тал бүр түүнийг хүлээн авах хүртэл аливаа Нэгдэн оролцогч талд хүчин төгөлдөр үйлчлэхгүй.

9.6 *Татгалзах*

9.6.1 Аливаа Нэгдэн оролцогч тал энэхүү Хэлэлцээрээс татгалзаж болно. Татгалзах тухай мэдэгдлийг ТХЕХ-т нэгдэгч ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУДЫН Ерөнхий Захирал бичгээр хүлээн авснаас хойш 12 сарын хугацаа дуусмагц татгалзал нь хүчин төгөлдөр болно. Аливаа Нэгдэн оролцогч тал нь ийм мэдэгдэлд тулгуурлан Хорооны хуралдааныг яаралтай хийх хүсэлт гаргаж болно.

9.7 Нэгдэн оролцогч тодорхой талуудын хооронд энэ Хэлэлцээрийг ашиглахгүй байх тухай

9.7.1 Тухайн үедээ энэхүү Хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн эсхүл түүнд нэгдэн орсон Талууд энэхүү Хэлэлцээрийг ашиглахыг зөвшөөрөхгүй бол Нэгдэн оролцогч аливаа хоёр талын хооронд энэхүү Хэлэлцээрийг ашиглахгүй.

9.8 *Хавсралт*

9.8.1 Энэхүү Хэлэлцээрийн Хавсралт нь хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

9.9 *Нарийн бичгийн дарга нарын алба*

9.9.1 Энэхүү Хэлэлцээрт ТХЕХ-ийн Нарийн бичгийн дарга нарын газар үйлчилнэ.

9.10 *Хадгалуулах*

9.10.1 Энэхүү Хэлэлцээрийг ТХЕХ-т нэгдэгч ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУДЫН Ерөнхий Захиралд хадгалуулахаар өгөх бөгөөд Ерөнхий Захирал нь



Нэгдэн оролцогч тал болон ТХЕХ-т нэгдэгч хэлэлцэн тохирогч тал тус бүрт түүний баталгаажуулсан хуулбар, 9.5 дугаар зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлт бүрийг, 9.1 дүгээр зүйлийн дагуу түүнийг хүлээн зөвшөөрсөн, түүнд нэгдсэн тухай эсхүл 9.6 дугаар зүйлийн дагуу татгалзсан тухайг даруй мэдэгдэж байна.

9.11 *Бүртгэх*

9.11.1 Энэхүү Хэлэлцээрийг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлийн заалтын дагуу бүртгүүлнэ.

1979 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Женев хотноо Англи, Франц хэл дээр нэг хувийг Үйлдэв, Хавсралт дахь жагсаалтуудад өөрөөр заагаагүй бол хоёр хэл дээрх бичвэр ижил тэгш хүчинтэй байна.⁵

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ
БАЙГУУЛЛАГА

ХЯЗГААРЛАЛТТАЙ
ТСА/4

2001 оны 11 дүгээр сарын 23-ны
өдөр
(01-5988)

Иргэний агаарын хөлгийн худалдааны Хороо

ИРГЭНИЙ АГААРЫН ХӨЛГИЙН ХУДАЛДААНЫ
ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
ОРОУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛ (2001)

Иргэний агаарын хөлгийн худалдааны Хэлэлцээрт (цаашид “Хэлэлцээр” гэх) Нэгдэн оролцогч талууд,

1992, 1996 болон 2002 онуудад танилцуулсан Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (цаашид “Уялдуулсан систем” гэх) болон Хэлэлцээрийн хамрах бүтээгдэхүүнийг өргөжүүлэх зэрэг өөрчлөлтийн хувилбаруудыг Хэлэлцээрийн Хавсралт болгох зорилгоор хэлэлцээ ЯВУУЛЖ,

⁵1987 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Хороо энэ Хэлэлцээрийн Испани хэл дээрх бичвэрийг мөн ижил тэгш хүчинтэй гэж зөвшөөрсөн.

тэдний төлөөлөгчдөөр дамжуулан, дараахь байдлаар
ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОВ:

1. Энэхүү Протоколд хавсаргасан Хавсралт нь 3 дахь хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болж, Иргэний агаарын хөлгийн худалдааны Хэлэлцээрийн Хавсралтад Нэмэлт өөрчлөлт Оруулах тухай Протокол (1986)-ын дагуу байгуулагдсан Хэлэлцээрийн Хавсралтыг орлоно.
2. Энэхүү Протокол нь 2001 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл эсхүл түүнээс хойш Иргэний агаарын хөлгийн худалдааны Хорооны шийдвэрлэсэн хугацаанд Хэлэлцээрт Нэгдэн оролцогч талууд гарын үсэг зурснаар эсхүл өөр байдлаар хүлээн авахад нээлттэй байна. ⁶
3. Энэхүү Протокол нь 2002 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үүнийг хүлээн зөвшөөрсөн Нэгдэн оролцогч талуудад хүчин төгөлдөр үйлчилнэ. Бусад Нэгдэн оролцогч талуудад үүнийг хүлээн зөвшөөрсөн өдрийн дараа өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
4. Энэхүү Протоколыг Дэлхийн Худалдааны Байгууллагын Ерөнхий захирал хадгалах бөгөөд энэхүү Протоколын баталгаажуулсан хувь болон 2 дугаар заалтын дагуу түүнийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдлийг Хэлэлцээрт Нэгдэн оролцогч тал бүрт мөн Дэлхийн Худалдааны Байгууллагын Гишүүн бүрт даруй хүргүүлж байна
5. Энэхүү Протокол нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу бүртгэгдэнэ.
6. Энэхүү Протокол нь зөвхөн Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн дагуу гаалийн татвар болон хураамжийн асуудлыг зохицуулна. Энэхүү Протоколд хамрагдах бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлөх горимоос бусад тохиолдолд, энэхүү Протокол эсхүл Хэлэлцээрийг шинэчилсэн, оруулсан өөрчлөлтүүд нь Дэлхийн Худалдааны Байгууллагыг байгуулах тухай Марракешийн Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд иш татсан ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА-ын аливаа Хэлэлцээрийн дагуу олгогдсон, энэхүү Протокол хүчин төгөлдөр болсон өдөр хүртэл Нэгдэн оролцогч талд байсан эрх, үүргийг өөрчлөх эсхүл түүнд нөлөөлөх зүйлгүй.

2001 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Женев хотноо ижил хүчинтэйгээр Англи, Франц, Испани хэл дээр нэг хувь үйлдэв.

⁶2001 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр Хороо нь Протоколыг хүлээн зөвшөөрөх хугацааг өөрөөр (ТСА/7) тогтоохоор шийдвэрлэв.



ХАВСРАЛТ

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

1. Бүтээгдэхүүний хамрах хүрээг Иргэний агаарын хөлгийн худалдааны Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд тодорхойлсон.
2. Нэгдэн оролцогч талууд нь, доор жагсаасан тодорхойлолтод хамаарах, Уялдуулсан системийн гарчиг, дэд гарчгийн дагуу зохих байдлаар ангилсан бүтээгдэхүүнийг, иргэний агаарын хөлөгт эсхүл газар дээрх нисэх дадлагажуур⁷ болон түүний үйлдвэрлэл, засвар, үйлчилгээ, сэргээн засварлах, өөрчлөлт эсхүл хувиргалтын явцад ашиглах бол татваргүй эсхүл татвараас чөлөөлөх горимд оруулахаар хэлэлцэн зөвшөөрөв.
3. Эдгээр бүтээгдэхүүнд дараахь зүйлс хамаарахгүй:

иж бүрдэл эсхүл бүрэн үйлдвэрлэж дууссан эд анги, бүрдэл хэсэг, угсралтын дэд хэсэг эсхүл иргэний агаарын хөлгийн эсхүл газар дээрх дадлагажуулагч төхөөрөмжийн тоноглолын (жишээ нь агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн эд ангийн дугаар бүхий эд зүйл) үндсэн гол шинжийг агуулснаас бусад иж бүрдүүлээгүй эсхүл бүрэн угсарч дуусаагүй бүтээгдэхүүн, иргэний агаарын хөлгийн эсхүл газар дээрх дадлагажуулагч төхөөрөмжийн угсралтад зориулан хэлбэр, хэмжээгээр нь зүссэн / эсхүл хэлбэр оруулснаас (жишээ нь агаарын хөлөг үйлдвэрлэгчийн эд ангийн дугаар бүхий зүйл) бусад аливаа хэлбэртэй материал (жишээ нь ялтас, хавтан, хийц, тууз, гулууз, хоолой, гуурс болон бусад хэлбэртэй),

түүхий эд болон хэрэглээний бүтээгдэхүүнүүд.

4. Энэхүү Хавсралтын зорилгын хүрээнд, “Ех”-тэмдэглэгээг, ишлэл хийж буй бүтээгдэхүүний тодорхойлолт нь Уялдуулсан системийндоорх гарчиг, дэд гарчигт жагсаасан нийт бүтээгдэхүүнийг бүгдийг нь хамраагүй гэдгийг тэмдэглэх зориулалтаар оруулсан байна.

⁷Энэ Хэлэлцээрийн 1.1 дүгээр зүйлийн хувьд, “газар дээрх симулятор”-ыг Уялдуулсан системийн 8805.29-ын дагуу газар дээрх нислэгийн дадлагажуулагч төхөөрөмж гэв.



Тэмдэглэл

*** (HS-- тээвэрлэлт зарагдсан, ачаа гэж тэмдэглэсэн код үг)

HS) Гарчиг Ex	HS Дэд гарчиг Ex	Тодорхойлолт
39.17	3917.21	Этилений полимерэн хатуу хоолой, гуурс, уян хоолой, холбогч эд ангийн хамт
39.17	.22	Пропилиний полимерэн хатуу хоолой, гуурс, уян хоолой, холбогч эд ангийн хамт
39.17	.23	Винил хлоридын полимерэн хатуу хоолой, гуурс, уян хоолой холбогч эд ангийн хамт
39.17	.29	Бусад төрлийн хуванцаран хатуу хоолой, гуурс, уян хоолой, холбогч эд ангийн хамт
39.17	.31	27.6 МПа-ын гал авалцах доод даралттай, хуванцар уян хатан хоолой, гуурс, уян хоолой, холбогч эд ангийн хамт
39.17	.33	Бэхжүүлээгүй эсвэл өөр материалтай хослуулаагүй, хуванцар холбогч эд ангийн хамт уян хатан хоолой, гуурс, уян хоолой холбогч эд ангийн хамт
39.17	.39	Бэхжүүлж эсвэл өөр материалтай хослуулсан, хуванцар уян хатан хоолой, гуурс, уян хоолой холбогч эд ангийн хамт
39.17	.40	Хуванцар уян хатан хоолой, гуурс, уян хоолойн тоноглол
39.26	3926.90	Бусад хуванцар эд зүйлс
